



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 27 өдөр

Дугаар Б/303

Улаанбаатар хот

Ж.Бадамлянхыг төрийн албанаас халах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 48 дугаар зүйлийн 48.1.4 дэх заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7, 17.1.8 дахь заалт, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам"-ын 3.4.1, 6.1 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/705 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь.

1.Нийслэлийн Баянзүрх дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн төрийн үйлчилгээний Дүнжингарав нэгдсэн төв дэх Улсын бүртгэлийн тасгийн иргэний улсын бүртгэгч Жамсранжавын Бадамлянх нь лавлагаа, мэдээллийг нотлох баримтаас зөрүүтэй, хуурамчаар гаргаж өгсөн нь хяналтын улсын байцаагчийн 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 3430 дугаар дүгнэлтээр тогтоогдсон тул түүнийг 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөр тасалбар болгон төрийн албанаас халсугай.

2.Ж.Бадамлянхын албан хэрэгцээнд хэрэглэж байсан 107 дугаартай улсын бүртгэгчийн тэмдгийг хүчингүй болсонд тооцсугай.

3.Ж.Бадамлянхын иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг цуцлахыг Иргэний улсын бүртгэлийн газар /Г.Нармандах/-т даалгасугай.

4.Төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг гаргуулж, холбогдох хууль тогтоомжийг сануулахыг нууц хамгаалах ажилтан /Г.Анхныбаяр/-д үүрэг болгосугай.

5.Ж.Бадамлянхтай холбогдох тооцоог хийж дуусган, үүрэгт ажлыг зохих журмын дагуу хүлээлцэхийг Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/-т, Баянзүрх дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс /П.Мөнхбаатар/-т, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т тус тус үүрэг болгосугай.

6.Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

14220-142